



УВС АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 1/1

Улаангом

Г Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх  
таван жилийн үндсэн чиглэл  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын "а", "е", 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого төвлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүний хөгжил, нийгмийн асуудлын хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", түүний хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хавсралтаар баталсугай.
2. Аймгийн Засаг дарга Ч.Чимэд/-д үүрэг болгох нь:
  - 2.1. "Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг олон нийтэд сурталчлан таниулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр батлагдсан төсөв болон бусад төсөл хөтөлбөрийн тусламжтайгаар санхүүжилтийг шийдвэрлэх
  - 2.2. "Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн явц, үр дүн, хүрсэн түвшинг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлagnаж байх
  - 2.3. Үндсэн чиглэлийн биөлэлтийн явц, хүрсэн түвшинг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх
3. Сумдын засаг дарга нарт даалгах нь:
  - 3.1. "Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан өөрийн сум, байгууллагатай холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг сумынхаа дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусган баталж, гүйцэтгэлийг жилээр тооцон, аймгийн Засаг даргын тамгын газарт тайлагнах
4. Таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд идэвх, санаачлагатай хамтран ажиллахыг аймгийн иргэний нийгмийн болон аж ахуйн нэгж, хувийн хэвшил, төсөл, хөтөлбөрийн байгууллагууд, иргэдэд уриалсугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дамдинсүрэн/-д үүрэг болгосугай.



АЙМГИЙН ИТХ-ЫН 2021 оны 01 наарын 06-ны  
өдрийн 4 дүгээр хурагдааны 4/01 тоот  
тогтоогийн хавсралт

## УВС АЙМГИЙГ 2021 – 2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Энэхүү Үндсэн чиглэлийг Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого "Алсын хараа-2050", Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулсан.

### НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

**Зорилго 1.** Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.

**Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:**

#### Үндэсний бахархал, эв нэгдэл

**Зорилт 1.1.** Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ.

1.1.1. Увс аймгийн түүхийн болон байгалийн дурсгал, дурсгалт газрууд, нүүдлийн хийгээд угсаатны өвөрмөц ахуй, соёл уламжлалыг хамгаалах, сэргээх, сурталчлах замаар аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, арга хэмжээг бий болгож хэрэгжүүлнэ.

1.1.2. Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг бэлтгэх, соёл, урлагийн байгууллагуудын ажиллах нөхцөл, орчныг сайжруулна.

#### Нүүдлийн соёл иргэншилт Монгол

**Зорилт 1.2.** Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.

1.2.1. Олон ястан, хүн ардын уламжлалт өвөрмөц ахуй, үндэсний онцлог, шинэ санаа, технологид сууриссан шинэлэг бүтээл зэргийг монгол үндэсний нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээж, хадгалж, өвлүүлнэ.

1.2.2. Соёлын өв, уламжлалыг хөгжүүлж бус нутгийн онцлог хэв шинжийг тусгасан хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжинэ.

#### Монгол хэл, бичиг

**Зорилт 1.3.** Үндэсний Монгол хэл, бичгээ эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.

1.3.1. Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлнэ.

1.3.2. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшиүүлнэ.

### **Эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл**

**Зорилт 1.4.** Үнэт зүйлийн болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааг салбар бүрээр хийж, нийтийн хүртээл болгоно.

1.4.1. Олон улсын Монгол судлал, судалгааны тэргүүлэх чиглэлийг өргөжүүлэх, тэдгээрийн үр дүнг түгээн дэлгэрүүлж, нийтийн хүртээл болгоход аймгийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.4.2. Олон үндэстэн, ястны үнэт зүйлийн судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, мэдээллийн сан бий болгож, судалгааны эргэлтэд оруулна.

### **Дэлхийн Монгол**

**Зорилт 1.5.** Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлнэ:

1.5.1. Олон ястан, Ойрад түмний уламжлалт ахуй, биет болон биет бус соёлын өвийг олон улсад таниулах, сурталчилах ажлыг нэмэгдүүлнэ.

## **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ**

**Зорилго 2.** Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшиүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.

**Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:**

### **Боловсрол**

**Зорилт 2.1.** Хүн бүрд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.

2.1.1. 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах, ясли, хүүхэд харах үйлчилгээг хэрэгжүүлнэ.

2.1.2. Ерөнхий боловсролын сургалтын чанарын үндэсний үнэлгээг жил бүр хийж, олон улсын үнэлгээнд хамруулна.

2.1.3. Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бий болгож, нийгмийн баталгааг хангана.

2.1.4. Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ.

2.1.5. Зайн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоон, сургалтын цахим орчныг хөгжүүлэн, багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлсэн насан туршийн боловсролын тогтолцоог бэхжүүлнэ.

2.1.6. УИХ, Засгийн газрын гишүүн, аймаг, сумын Засаг даргын болон аж ахуйн нэгж, байгууллагын тэтгэлэгээр хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр дотоод, гадаадад сургана.

2.1.7. Спорт сургалтын төрөлжүүлсэн төвийг зарим суманд байгуулах, сургалтын материаллаг болон үйлийн орчинг суралцагч бүрт дэвшилтэг технологи, ухаалаг, хүртээмжтэй байхаар тооцож бэхжүүлнэ.

2.1.8. Сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байруудыг стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгож, эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох орчин нөхцөлөөр хангана.

2.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулж, тусгай хэрэгцээт сургалтын орчинг бүрдүүлнэ.

### **Эрүүл мэнд**

#### **Зорилт 2.2. Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ:**

2.2.1. Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлж, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан, иргэдийн халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.

2.2.2. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн санг баяжуулж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.

2.2.3. Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэг технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.

2.2.4. Эрүүл мэндийн байгууллагуудын ажлын нөхцөл, байр, орчныг сайжруулж, салбарын хүний нөөцийн үр чадвар, нийгмийн хамгааллыг дээшлүүлнэ.

### **Гэр бүл**

#### **Зорилт 2.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ:**

2.3.1. Хүүхдийн хөгжил, авьяас, үр чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулна.

2.3.2. Залуу гэр бүлийг дэмжинэ.

2.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.

**2.3.4. Хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл эүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс анgid байлгах чиглэлээр хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана.**

#### **Шинжлэх ухаан, технологи, инновац /шинэ санаа/**

**Зорилт 2.4. Шинжлэх ухаан, технологийн санаачилгыг орон нутгийн тогтвортой хөгжлийн үндсэн хүчин эүйлсийн нэг болгон ашиглана.**

**2.4.1.** Шинэ мэдлэг, патент, шинэ санаачлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн, эдийн засгийн эргэлтэд оруулахад эрдэм шинжилгээний салбар байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

**2.4.2.** Шинжлэх ухааны бүтээл, судлаачдын судалгааны үр дүнг коллеж, дээд сургуульд эрэлтээ мэргэжлээр нарийн мэргэшүүлэх сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, мэдээллийн санг арвижуулна.

**2.4.3.** Аймгийн лабораториудын техник технологи, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ.

#### **Хүнд ээлтэй амьдрах орчин**

**Зорилт 2.5. Эрүүл баталгаат орчныг бий болгоно:**

**2.5.1.** Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавхийг нэмэгдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангана.

**2.5.2.** Агаар, ус, хөрсний бохирдлыг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.

**2.5.3.** Хүнс үйлдвэрлэлийн үе шат бүрд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.

**2.5.4.** Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлцуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**2.5.5.** Орон сууц, гадна зам талбай, гэр хороололд ногоон байгууламжийг стандартын дагуу хороолол, хотхонаор төлөвлөн ажиллана.

#### **Хөдөлмөрийн зах зээл**

**Зорилт 2.6. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хэлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ.**

**2.6.1.** Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, үйлчилгээний хүртээмж, цалин хэлс, урамшууллын оновчтой хэлбэрийг мөрдөнө.

**2.6.2.** Хөдөлмөр эрхлэлтэд үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**2.6.3.** Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ.

**2.6.4.** Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.

## **Монгол хүний удмын сан**

**Зорилт 2.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ:**

- 2.7.1. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг хөгжүүлнэ.
- 2.7.2. Цус ойртолтоос сэргийлэх, удамшлын өвчин болон төрөлхийн соготой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ.

## **ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА**

**Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.**

**Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:**

### **Нийгмийн хамгааллын шинэчлэлийг хэрэгжүүлнэ**

**Зорилт 3.1. Нийгмийн хамгааллын шинэ тогтолцоог хэрэгжүүлнэ.**

- 3.1.1. Иргэд бодит хуримтлалтай болох, даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.
- 3.1.2. Иргэн бүр нэрийн дансандaa бодит хуримтлалтай болж, дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэлийг хэрэгжүүлнэ.
- 3.1.3. Нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно.
- 3.1.4. Хүн амын бүлгүүдийн ялгаатай, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.

### **Орлогод нийцсэн орон байр**

**Зорилт 3.2. Өрж, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах бодлого хэрэгжүүлнэ.**

- 3.2.1. Гэр хорооллын дэд бүтцийн хөгжилд суурилсан амины орон сууцны нэг маягийн зураг төсөв, өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.2.2. Барилгын үндсэн нэр төрлийн зарим материалыг дотооддоо үйлдвэрлэх замаар импортын бүтээгдэхүүнийг бууруулна.
- 3.2.3. Орон сууцны дахин төлөвлөлтийг оршин суугчид, төр-хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

### **Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес**

**Зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.**

- 3.3.1. Залуучуудын бүтээлч санаачлага, гарцааны болон бичил, жижиг, дунд бизнесийг дэмжинэ.
- 3.3.2. Малчид, тариаланчдыг бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болгоно.
- 3.3.3. Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 3.3.4. Хоршоо, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжинэ.

#### **Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт**

**Зорилт 3.4. Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлнэ:**

- 3.4.1. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, сум хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар зорилтолт бүлэгт хүргэж, төслийн үр дүн, эргэн төлөлт, хяналтыг сайжруулна.
- 3.4.2. Уламжлалт ахуйгаа дээдлэн, өндөр технологи бүхий хөдөө аж ахуй – аялал жуулчлалын бизнесийг оновчтой хослуулсан, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

#### **Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг**

**Зорилт 3.5. Биеийн тамир, спортын чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна.**

- 3.5.1. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, спортын холбоод, хувийн хэвшлийн түншлэлд сууринсан нээлттэй, уян хатан арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.5.2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж, орчин нөхцөлийг сайжруулна.
- 3.5.3. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.

#### **Газрын харилцаа**

**Зорилт 3.6. Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, үр дүнд сууринсан хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бурдүүлнэ.**

- 3.6.1. Аймгийн тэв Улаангомыг хотын зэрэглэлд шилжүүлнэ.
- 3.6.2. “Нэг иргэн – Нэг бүртгэл” бодлогыг хэрэгжүүлж, хаягжилтын нэгдсэн системийг аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.
- 3.6.3. Газар өмчлөл, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэлийг нэмэгдүүлэх, газрын үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ.
- 3.6.4. Аймгийн хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй суурин, захуудыг төрөлжүүлж, байршил, орон зайн төлөвлөлтийг хийнэ.

#### **ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ**

**Зорилго 4.** Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хурийтлалын чадавхаа дээшлүүлсэн аймаг болно.

**Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:**

**Чинээлэг иргэн**

**Зорилт 4.1. Аймгийн эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, төсөв санхүүгийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ.**

4.1.1. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн механизмыг ил тод, нээлттэй хэрэгжүүлнэ.

4.1.2. Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ.

4.1.3. Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.

4.1.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан, дотоодын болон орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ.

**Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд**

**Зорилт 4.2. Аймгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэн тогтоож хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:**

4.2.1. Иргэдийг чанартай, эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангах, олон улсын чанар, стандартыг нэвтрүүлсэн, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, хоршооны хөгжлийг дэмжих, орон нутагт шинэ ажлын байр бий болгох зорилго бүхий хөдөө аж ахуйн "ШИНЭ ХӨДӨӨ-УВС", "УВС-АГРО" хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор төслийг хэрэгжүүлнэ.

4.2.2. Аймгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

4.2.3. Баруун бүсийн тээвэр, логистикийн төвийг байгуулна.

4.2.4. Орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулаан, сэргээгдэх эрчим хүчний эх Үүсвэрийг нэмэгдүүлнэ.

4.2.5. Хариуцлагатай уул уурхайг дэмжиж, аймгийн нөөц баялагт тулгуурлан /нүүрс, давс, төмрийн хүдэр, барилгын материал/ боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжинэ.

4.2.6. Увс нутгийн язгуур үнэт зүйл, өв соёл, байгаль, цаг уур, бахархалд тулгуурласан шинэ бүтээлийг бий болгож хөгжүүлнэ.

**Ухаалаг санхүүгийн зах зээл**

**Зорилт 4.3. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид сууринсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ:**

- 4.3.1. Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээг тэлнэ.
- 4.3.2. Банк санхүү, даатгалын байгууллагуудын найдвартай байдлыг хангуйж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

#### **Бүс нутгийн хамтын ажиллагаа**

**Зорилт 4.4. Хөрш болон бусад орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа чөлөөт худалдааг аймгийн онцлогт нийцүүлэн хөгжүүлнэ.**

- 4.4.1. ОХУ болон БНХАУ-ыг холбосон эдийн засгийн коридорыг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.
- 4.4.2. Гуравдагч орнуудтай худалдаа, эдийн засаг, нийгэм, соёлын харилцааг өргөжүүлнэ.

#### **Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн**

**Зорилт 4.5. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ:**

- 4.5.1. Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, нөөц, брэндэд тулгуурласан, зах зээлд өрсөлдөхүйц бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 4.5.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

#### **Үндэсний баялгийн сан**

**Зорилт 4.6. Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ:**

- 4.6.1. Аймагт үйл ажиллагаа эрхэлдэг төмрийн хүдэр, нүүрсний болон бусад уурхайн үйлдвэрийн ашиг хүртэгч эзэдтэй хамтран, хөрөнгийн хуримтлал бий болгож, орон нутаг, айл өрхийн хөгжлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.

### **ТАВ. ЗАСАГЛАЛ**

**Зорилго 5. Цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшөн, авлигагүй аймаг болно.**

**Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:**

#### **Ухаалаг засаглал**

**Зорилт 5.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх аймгийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлнэ.**

5.1.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд үүрэн холбоо, хэвлэл мэдээллийн болон цахим хэрэгслийг ашиглан, төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй хамtran, тэдгээрийн үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ.

5.1.2. Иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг өргөтгэж, сүм, байгууллага бүр сургалтын төвүүдээр дамжуулан тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

### Ухаалаг бүтэц

**Зорилт 5.2. Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бий болгоно.**

5.2.1. Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг нэмэгдүүлнэ.

5.2.2. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, худалдаа, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хамtran ажиллах хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.

5.2.3. Төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

### Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)

**Зорилт 5.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ:**

5.3.1. Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо, үйлчилгээний үр дүнг сайжруулна.

5.3.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлагналтын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем нэвтрүүлнэ.

5.3.3 Цахим засаглалыг хөгжүүлж, өндөр хурдны интернэтийн орчинг сайжруулж, хэрэглээг нэмэгдүүлнэ.

### Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба

**Зорилт 5.4. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нелөөг дээшлүүлнэ:**

5.4.1. Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшүүлнэ.

5.4.2. Улс төрийн намд үйлчилдэггүй, хараат бус төрийн албыг бий болгож, төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн албанд шатлан дэвшүүлэх тогтолцоог хэрэгжүүлнэ.

5.4.3. Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

5.4.4. Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.

5.4.5. Захиргааны байгууллагаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмжийн талаар хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэнэ.

5.4.6. Төрийн үйлчилгээний чанарын стандарт хэрэгжиж, иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёлыг төлөвшүүлнэ.

5.4.7. Орон нутагт томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг сайжруулна.

#### **Хүний эрхийг дээдэлсэн нийгэм**

**Зорилт 5.5. Хүний эрхийг хангах олон талт түншлэлийг хөгжүүлнэ:**

5.5.1. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллана.

5.5.2. Хүний эрхийг хангах, хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.

#### **Авлигагүй засаглал**

**Зорилт 5.6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн бодлогыг хэрэгжүүлж шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.**

5.6.1. Авлигатай тэмцэх үндэсний хетөлбөрийг хэрэгжүүлж, соён гэгээрүүлэх ажлыг хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

### **ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ**

**Зорилго 6. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.**

**Зорилтын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:**

#### **Эх байгаль анхдагч экосистем**

**Зорилт 6.1. Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистем бүхий газар нутгийг судалж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг үнэлнэ.**

6.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг зохист хэмжээнд барьж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаална.

#### **Байгалийн баялгийн үр өгөөж**

**Зорилт 6.2. Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулна.**

6.2.1. Газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилт, элсний нүүлтээс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна.

- 6.2.2. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.
- 6.2.3. Хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийнэ.
- 6.2.4. Ойн нөөцийг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтад туслах, ойн цэвэрлэгээний ажлын талбайг нэмэгдүүлэх, ойн аж ахуйн арга хэмжээг зохион байгуулна.
- 6.2.5. Амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийн судалгааг өргөжүүлэх, ашиглалтад өртөмтгийн амьтан, ургамлыг зориудаар хамгаалж өсгөх ажлыг зохион байгуулна.

### **Үнэт баялаг ус**

**Зорилт 6.3. Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.**

6.3.1. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна.

6.3.2. Хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цеерем, усан сангууд байгуулж, ус ашиглалтын нөөцийг нэмэгдүүлнэ.

6.3.3. Нийт хүн амыг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангана.

### **Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил**

**Зорилт 6.4. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлнэ.**

6.4.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сээрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.

6.4.2. Ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

6.4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг болосруулж, хог ангилах, дахин боловсруулах үүсгэл санаачилгыг дэмжинэ.

## **ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ**

**Зорилго 7. Үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд анхаарна.**

**Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:**

### **Зэвсэгт хүчин**

**Зорилт 7.1. Мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд аймаг орон нутгийн оролцоог нэмэгдүүлнэ.**

- 7.1.1. Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг бүх нийтэд сурталчилан таниулна.
- 7.1.2. "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлнэ.
- 7.1.3. Аймгийн Цэргийн штабын албаны бэлэн байдлыг хангаж, сургалтын материаллаг баазыг бэхжүүлнэ.
- 7.1.4. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.

#### **Дархан хил**

**Зорилт 7.2. Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшилийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ.**

- 7.2.1. Хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг яштал хэрэгжүүлнэ.
- 7.2.2. Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж, албаны бэлэн байдлыг дээшлүүлнэ.

#### **Хүн, нийгмийн амар тайван байдал**

**Зорилт 7.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, тэр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ:**

- 7.3.1. Иргэдийг хил дамнасан гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэхэд инновацад суурилсан техник, технологийн дэвшилийг нэвтрүүлнэ.
- 7.3.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 7.3.3. Орон нутгийн гамшигаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.
- 7.3.4. Аймгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, тооцоо судалгаанд суурилсан удирдлага менежментийг хэрэгжүүлнэ.
- 7.3.5. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээг сийажруулна.
- 7.3.6. Иргэд, гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.

#### **Хууль сахиулах салбарын хөгжил**

**Зорилт 7.4. Хууль сахиулах салбарын эрх зүйн орчиныг хэрэгжүүлж, материаллаг баазыг бэхжүүлнэ:**

- 7.4.1. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулна.
- 7.4.2. Төрийн архивыг зохион байгуулалтын хувьд бие даасан нэгж байхаар тогтоож, орон тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 7.4.3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах боломж, нөхцөлийг дээшлүүлнэ.
- 7.4.4. Мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.
- 7.4.5. Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангана.
- 7.4.6. Хууль сэхиулах байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлнэ.

#### **Мэдээллийн аюулгүй байдал**

**Зорилт 7.5. Цахим аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана:**

- 7.5.1. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг сайжруулна.
- 7.5.2. Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн хараат байдлыг бууруулж, цахим гэмт хэрэг, халдлагаас хамгаална.

### **НАЙМ. БҮС, СУМ, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ**

**Зорилго 8.** Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.

**Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:**

#### **Дэд бүтэц**

**Зорилт 8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно:**

- 8.1.1. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээ, тээвэр логистикийн тогтолцоог хэрэгжүүлнэ.
- 8.1.2. “Боршоо” боомтын цогцолбор байгуулж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх, олон улсын стандартад нийцуулэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.

- 8.1.3. "Дэглий цагаан" нисэх буудлын хүчин чадлыг сайжруулж, үйл ажиллагааг өргөжүүлэх, зарим сумдад ерөнхий зориулалтын нисэх үйлчилгээг бий болгоно.
- 8.1.4. Засгийн газрын "Бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хүрээнд бүсийн болон хил залгаа аймгуудтай хамтран ажиллах чиглэлээ тодорхойлж, төслийг хэрэгжүүлж эхэлнэ.
- 8.1.5. Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, зарим сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 8.1.6. Увс-Ховд аймаг чиглэлийн хатуу хүчилттай авто замыг барьж, баруун бүсийн А-07, А-1702, А-18 замын дагуух сумдыг улсын чанартай автозамтай үе шаттай холбох ажлын эхлүүлнэ.
- 8.1.7. Гэр хороолол, орон сууцны дахин төлөвлөлт, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл шинэчлэл хийж, цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна.
- 8.1.8. Ус хангамж, ариутгах татуурга, дулааны эрчим хүчний инженерийн дэд бүтэц, Улаангомын цэвэрлэх байгууламжийг шинээр байгуулах,
- 8.1.9. Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.

### **Аялал жуулчлал**

**Зорилт 8.2. Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ:**

- 8.2.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 8.2.2. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлнэ.

### **Тогтвортой хөдөө аж ахуй**

**Зорилт 8.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, здийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:**

- 8.3.1. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хөгжлийг дэмжих, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын болон орон нутгийн үйлдвэрлэлээр тогтвортой хангах, төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дэмжинэ.
- 8.3.2. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, мал эмнэлгийн үргжлийн нэгжүүдэд хийх хяналтийг сайжруулж, мал, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 8.3.3. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хортон мэрэгчтэй тэмцэх, бэлчээрийн даац багтаамж, ашиглалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна.
- 8.3.4. Малын генийн санг хамгаалах, нутгийн шилмэл үүлдрийн малыг өсгөж нийт малд эзлэх хувийг нэмэгдүүлэх биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, цөм сүрэг, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.

- 8.3.5. Хээлтүүлэгч малыг зэмэгжүүлж бүртгэл мэдээлийн нэгдсэн санд оруулах, малын төрөл хоорондын зохистой харьцааг бүрдүүлэх, эдийн засгийн эргэлтэнд оруулна.
- 8.3.6. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанарт анхаарах, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, тээвэр, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, хоршоодын хөгжлийг дэмжинэ.
- 8.3.7. Тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх, үр тариа болон голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг хангах, бусад ашигт таримлын үйлдвэрлэл болон хүлэмж, зоорь агуулахыг нэмэгдүүлнэ.
- 8.3.8. Малын тэжээлийн нэр төрөл, чанар, хангамжийг нэмэгдүүлэх, тэжээлийн нэг ба олон наст ургамал, уургийн агууламж ихтэй шинэ таримал тариалах, тэжээлийн үйлдвэрийг бий болгоно.
- 8.3.9. Малчдыг сургах, малжуулах, МАА-н мэргэжилтнүүдийг бэлтгэх, чадавхижуулах ажлыг хэрэгжүүлж, малчдын орлогыг нэмэгдүүлэх фермерийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 8.3.10. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих санхүүжилтийн шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлж, бизнес төвийн үйлчилгээгээр бойжуулж, үр чадварыг хөгжүүлэн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- 8.3.11. Дундын хоршооны үйл ажиллагааг дэмжиж, хөдөө аж ахуйд технологи суурьтай инновацийг нэвтрүүлж, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.
- 8.3.12. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэн, тэдгээрийг боловсруулах үйлдвэрүүдийг дэмжиж ажиллуулна.
- 8.3.13. Чацаргана, жимс жимсгэний үйлдвэрийн кластерыг дэмжиж, бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ, үр сортын шинэчлэлийг тууштай дэмжинэ.

Аймгийн ГХЧН 2021 оны 01 сарын 06-ны  
өдрийн 4 дугаар шандланын 4/01 тоот  
хүчинчлийн хөвсргэлт

**“УВС АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖЛҮЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ИНТЕГРИРОВАНЫЙН ШИРГҮҮР УЗҮҮЛЭЛТ,  
ХҮРЭХ ТUVШИН**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нүүц	Суурь түвшин	Хүрэх түвшин				Шалгуур үзүүлэлтийн таймбар	Мэдээлэл шүгчүүлах давтамж	Хариуцах байгууллага	
				2021	2022	2023	2024				
<b>НЭГ. ҮНДСЭНИЙ НӨГӨМӨЛЧИЙН ТЭМЖИЙН</b>											
1	Номын фонддын номыг цахим каталогт оргуулсан номын зээлэх хувь	хувь	58.5	65	70	80	90	100	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг удаа	НБХ БСУГ Номын сан
2	Соёл, урлагийн мэргэжлийн боловсон хүчний хангалтын хувь	хувь	58.4	59.5	64.0	64.9	70.0	80.0	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг удаа	НБХ БСУГ СХ
3	Соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	тоо	4891	4891	5475	5475	5475	5475	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг удаа	НБХ БСУГ
4	Соёл, урлагийн үйлчилгээний хургалдаж	хувь	0.40	0.45	0.50	0.55	0.55	0.60	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг удаа	НБХ БСУГ
5	Үндэсний язгуур өв соёлыг сэргээн тавьсан уран бузэлийн тоо	тоо	0	1	1	1	1	1	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг удаа	НБХ БСУГ
6	Музейн байгууллагаар үйлчилгээгүйн тоо	тоо	4600	5655	6600	7500	8500	10000	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг удаа	НБХ БСУГ
7	Музейн үзмэрийн тоо	тоо	9331	9343	9358	9370	9385	9401	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг удаа	НБХ Музей
8	Соёлын биет бус өвлийг өвлөн уламжлагчийн тоо	тоо	401	410	420	430	440	450	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг удаа	НБХ БСУГ
9	Төрийн албан хаанчын Монгол бичгээр бичих, унших	хувь	34	36	38	40	42	44	2019 оны суурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг удаа	НБХ БСУГ

ЧАДВАРЫН ХУВЬ		ХӨӨРЧХҮНИЙ ХӨГЖИЛ										
		ИНДЕКС	ИНДЕКС	ИНДЕКС	ИНДЕКС	ИНДЕКС	ИНДЕКС	ИНДЕКС	ИНДЕКС	ИНДЕКС	ИНДЕКС	
1	Хүний хөгжлийн үзүүлэлт	0.653	0.655	0.658	0.660	0.662	0.665	2019 оны суурь тувшин	Жилд нэг удаа	НБХ Статистикийн хэлтэс		
2	Жендерийн тэтийн бус байдлын үзүүлэлт	0.803	0.800	0.795	0.790	0.780	0.770	2019 оны суурь тувшин:	Жилд нэг удаа	НБХ Статистикийн хэлтэс		
3	СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин	хувь	91.8	92	92.3	92.6	92.8	93.0	Боловсролын салбарын статистикаас гарна.	Жилд нэг удаа	НБХ БСУГ	
4	5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдлал	хувь	92.8	94.0	94.5	96	97.5	100	Боловсролын салбарын статистикаас гарна.	Жилд нэг удаа	НБХ БСУГ	
5	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	90.2	91.0	91.5	92.0	92.5	93.0	Боловсролын салбарын статистикаас гарна.	Жилд нэг удаа	НБХ БСУГ	
6	Цэцэрлэгийн бүтгийн багшид ногдох хүүхдийн тоо	тоо	29.1	28.5	28.0	27.5	27.3	27	Боловсролын салбарын статистикаас гарна.	Жилд нэг удаа	НБХ БСУГ	
7	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	25.3	25.3	25.2	25.1	25	25	Боловсролын салбарын статистикаас гарна.	Жилд нэг удаа	НБХ БСУГ	
8	Булэг дүүргэлт (боловсролын бүх түвшнээр)	тоо	Цэцэрлэг-31.4 ЕБС-25.4	31.0 25.3	30.8 25.2	30.0 25.1	29.0 25.1	28 25	Боловсролын салбарын статистикаас гарна.	Жилд нэг удаа	НБХ БСУГ	
9	Элсэлтийн өрөнхий шалгалтын дундаж оноо	тоо	509.9	511	511.5	512	512.5	513	Боловсролын салбарын статистикаас гарна.	Жилд нэг удаа	НБХ БСУГ	
10	Насан түршийн боловсролын үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хувь	хувь	30	40	50	60	65	70	Боловсролын салбарын статистикаас гарна.	Жилд нэг удаа	НБХ БСУГ	
11	Хүн амын дундаж наслалт	жил	69.7	70	70.3	70.6	71.3	71.8	2019 оны суурь тувшин	Жилд нэг удаа	НБХ Статистикийн хэлтэс	
12	Төрөлтийн нийлбэр коэффициент (нэг)	тоо	3	3.1	3.15	3.3	3.25	3.3	ЭМ-ийн байгууллагын статистик	Жилд нэг удаа	НБХ Статистикийн	

																		хэлтэс	
13	эмэгтэйд нөхдох 1000 амьд төрөлтэд ногдох наядсын эндэгдлийн түвшин	промилъ	13.6	13	12.5	12	11.5	11	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ Статистикийн хэлтэс								
14	5 хүртэлх наасны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтэнд/	промилъ	17.8	15.5	15.3	15.1	14.9	14.7	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ Статистикийн хэлтэс ЭМГ								
15	1000 амьд төрөлтэд эхийн эндэгдлийн харьцаа	промилъ	0	0	0	0	0	0	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ, ЭМГ, СХ								
16	Тухайн жилийн төвлөлт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	99.0	99.0	99.0	99.0	99.0	99.0	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ЭМГ СХ								
17	Хорт хавдрын эрт иэрүүлэлтийн хувь	хувь	14.5	15.0	16.0	17.0	18.0	19.0	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ЭМГ СХ								
18	Артерийн даралт ижсэх ёвчний эрт иэрүүлтийн хувь	хувь	96.5	96.8	97	97.2	97.5	98	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ЭМГ СХ								
19	Чихрийн шижин ёвчний ўеийн эрт иэрүүлтийн хувь	хувь	93.7	93.9	94.1	94.3	94.5	94.7	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ЭМГ СХ								
20	10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	18	1.7	1.5	1.4	1.3	1.2	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ЭМГ СХ								
21	Нийт халдварт өвчин /10 000 хүн амд/	промилъ	74.9	73.6	73.3	73	72.7	72.4	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ЭМГ СХ								
22	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	хувь	90.5	90.8	91.3	91.8	92.3	93.0	ЭМ-ийн байгууллагын статистик 2019 оны сурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ЭМГ СХ								
23	Гэр булийн хүчирхийлийн улмаас үйлдэлдсэн гэмт хэргийн тоо	тоо	15	14	13	12	11	10	Маргажийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын жилд нэг уудаа	хэзэх, НБХ ЦГ ГБХЗХГ								
24	Зөрчлийн тухай хулиар	тоо	125	124	123	122	121	120	Мэргэжлийн статистикаас	байгууллагын жилд нэг уудаа	хэзэх, НБХ ЦГ								

2019 оны суурь үзүүлэлт										ГБХЭХГ	
шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийлийн тоо											
25 Ажилгүйдлийн түвшин	хувь	11.1	10	9.1	9	8.7	8.5	Суурь түвшин 2019 оны 4-р улирал	Жилд нэг удаа	НБХ СХ	
26 Шинээр бий болгосон эжлын байрны тоо	тоо	1200	1200	1200	1200	1200	1200	Жил бүр шинээр гарсан ажлын байр 2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ХҮГ	
Эдийн засгийн идэвхгэй хүн ам (ажиллах хүч)-ын чамрагдсан хувь	хувь	49.4	50.3	54.5	54.8	55.1	55.4	НДХ-ээс статистик үзүүлэлтээс гарах 2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	НБХ НДХ	
Нийгмийн даатгалд эжил олгогчийн камрагдалтын хувь	хувь	59.4	60.3	61.3	61.6	61.9	62.1	НДХ-ээс статистик үзүүлэлтээс гарах 2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	НБХ НДХ	
28 Ажиллах хүчиний оропдооны хувь	хувь	68.2	68.2	69.0	69.5	70.0	71.0	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	НБХ НДХ	
29 Угийн бичигт хөтөлдөг эрхийн нийт өрхөд залэх хувь	хувь	7	12	17	22	27	30	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ГБХЭХГ	
<b>ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧИНАР БАДУНЦАЖ ДАВХАРГА</b>											
1 Ядуурлын түвшин	хувь	29.6	28.4		26.0		25.0	2018 оны суурь түвшин	2 жилд нэг удаа	НБХ Ундэсний статистикийн хороо	
2 1, 2-р түвшиний өрхийн тоо	тоо	5530	5420	5312	5206	5102	5000	Эрхийн амьжиргааны түвшин тогтоох 1,2-р түвшиний өрхийн тоо 2017 оны суурь түвшин	Жилд нэг удаа	НБХ ХҮГ	
Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдарын хөгжлийн суурь үзүүлэлт	хувь	66.7	67.0	67.5	68.0	68.5	69.0	БТС-ын газрын статистик мэдээлэл 2019 оны суурь үзүүлэлт	Жилд нэг удаа	НБХ БТСГ	
Инженерийн бүрэн хангамжтай орон сууцнаар хангаждсан өрхийн хувь	хувь	9.6	10	10.3	10.5	10.7	11.0	Маргажийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	Жилд нэг удаа	ХОХБТХ	
<b>ДӨРӨВЛ. ЭДИНН ЗАСАТ</b>											
1 Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлогого тооцох 2019 оны суурь түвшин	тэр.төгр	417.9	427.5	448.8	480.0	520.0	590.0	Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлогого тооцох 2019 оны суурь түвшин	Жил бүр	НБХ СХ	

2	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээдэхүүний хэмжээ	мян.төг	5019.2	5038.5	5270.0	5500.0	6200.0	6500.0	Нэг хүнд ногдох дотоодын нийт тооцох Бүтээдэхүүний хэмжээ аргачалгаар 2019 оны суурь тувшин	Жил бүр	НБХ СХ
3	Эдийн застийн тамир тэнхээ	оноо	53	54.5	55	55.5	56	56.5	Аймгуудын тайлантийн гэнхээний Учэлэгээр Суурь тувшин 2019 онсоо/	Чадварын эдийн засгийн Тамир Жил бүр	ЭЗБӨЧСТ
<b>ТАВ. ЗАСАГЛАЛ</b>											
1	Шударга байдлын унэлгээний хувь	хувь	72.4	72.6		72.8		73.5	АТГ-ийн жил бүр зохион байгуулдаг ШБТҮ-ний дун Авлинын эсрэг хуулийн 18.1.7-д заасан ундэслэлээр 2 жил тутамд нэг удаа хийгдэг. Суурь тувшин 2019 он	Жилд 1 удаа	АТГ ХЭЭХ
2	Хэрэллэгчийн унэлгээний дун	оноо	2.89	3.0		3.2	3.2	3.3	Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид өгөх иргэдийн сэтэл ханамжийн тухайн жилийн унэлгээ Суурь тувшин ЗГХЭГ-аас авсан 2019 оны хэрэллэгчийн үнэлгээний дун	Жилд 1 удаа	ЗГХЭГ ХҮСДАХ ТЭҮХ
<b>ЗУРГАА НОГООН ХӨГЖИЛ</b>											
1	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	хувь	23.3	24	25	26	27	27	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	Жилд 1 удаа	ХОХБТХ БОАЖГ
2	Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талаiban эзлэх хувь	хувь	53.9	55	57	58	60	66	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	Жилд 1 удаа	ХОХБТХ БОАЖГ
3	Шаардлага хангасан ундны усны эх гусвэрээр хангасан хун амын эзлэх хувь	хувь	42.2	45	50	55	60	66	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	Жилд 1 удаа	ХОХБТХ БОАЖГ
4	РМ2.5 тоосонцорын жилүүдийн дундаж агууламж	мкг/м3	48	47	47	46	46	46	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	Жилд 1 удаа	ХОХБТХ ҮЦҮШГ
5	РМ10 тоосонцорын жилүүдийн дундаж агууламж	мкг/м3	64	63	62	62	62	62	Мэргэжлийн статистикаас 2019 оны суурь үзүүлэлт	Жилд 1 удаа	ХОХБТХ ҮЦҮШГ

**ДОЛГОО, АМАР ТАЙВАН, АЮУЛГҮИ НИЙГЭМ**

1	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	327	325	323	320	310	309	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХЭЭХ ЦГ
2	Иргэдэд учирсан хөхирлын нөхөн төлгүүлэлтийн хувь "Оюутган цэрэг"	хувь	60.6	66.1	70	74	78	80	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХЭЭХ ЦГ
3	сургалтад хамрагдах сургалцагчдын тоо	тоо	10	10	10	10	10	10	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ЦШтаб
<b>НАИМ БУС, ОРООН НУТГИИН ХӨГЖЛИЙН</b>												
1	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн зимын эзлэх хувь	хувь	51.1	52	53	54	55	56	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХОХБТХ
2	Цахилгаан эрчим хүчний шугамын алдагдлын бууралт	хувь	17.3	17.0	16.5	16.0	16.5	15.0	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХОХБТХ
3	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт	км	0	-	-	-	163.3	-	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХОХБТХ
4	Стандарт шаардлага хангасан жуулчны баазын тоо	тоо	21	23	24	24	26	26	Мэргэжлийн статистикаас 2020 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХОХБТХ БОДЖ
5	Хураан авсан тариа	мян.тн	30.9	30.91	30.94	31.0	31.5	32.0	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХОХБТХ ХХААГ
6	Хураан авсан малтын тэжээл	мян.тн	9.2	9.3	9.35	9.4	9.5	10.0	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХОХБТХ ХХААГ
7	Хураан авсан хүнсний ногтоо	тн	2782.8	2800.0	2850.0	2900.0	2950.0	3000.0	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХОХБТХ ХХААГ
8	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний ханчамжийн түвшин /МАХ, СҮУ, хүнсний ногтоо, жимс жимслэнэ/ Нутгийн шилмэл омог,	хувь	68	70	72	74	76	78	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХОХБТХ ХХААГ
9	Улдрийн малын тоог өстөх	тоо	417000	417400	417900	418600	419500	420500	Мэргэжлийн статистикаас 2019 оны сурь үзүүлэлт	байгууллагын байгууллагын	Жилд 1 удаа	ХОХБТХ ХХААГ
10	Олон улсын	тоо	0	-	1	-	-	-	2019 оны сурь үзүүлэлт	Жилд 1	ХОХБТХ	

зэрэглэлтэй болгох  
 нисэх буудлын тоо

удаа

-00-